



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/440

Мандалговь

“Хур Харцага дэвжээ”-ний бөхчүүдэд  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь нутгийн “Хур Харцага дэвжээ”-ний бөхчүүдийн амжилтыг ахиулах, залгамж халааг бэлтгэх боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтарсан бэлтгэл сургуулилт хийх заал танхим ашиглахад дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дэмжлэг үзүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.
3. Дэмжлэгт шаардагдах зардалд 6,300,000 (Зургаан сая гурван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

431210643

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын  
09-ны өдрийн 11 дүгээр захирамжийн хавсралт

ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Зардлын утга                  | Тоо<br>хэмжээ        | Нэг бүрийн<br>зардал | Бүгд зардал |
|---|-------------------------------|----------------------|----------------------|-------------|
| 1 | Спорт заалны түрээсийн төлбөр | 126 цаг<br>/63 удаа/ | 50,000               | 6,300,000   |
|   | ДҮН                           |                      |                      | 6,300,000   |